

## БЭЭЖИН ХОТ-ОЛИМПИЙН ЭЗЭН ХОТ БОЛСОН ТҮҮХЭЭС

Олон Улсын Олимпийн Хороо (ОУОХ) 1999 онд хуралдаж 110-р чуулганаараа Олимпийн наадмын эзэн хотыг шалгаруулах 2 шаттай сонгуулийн тогтолцоог баталж, 2008 оны Олимпийн наадмыг зохион байгуулагчийг сонгох үеэс энэ журмыг хэрэглэхээр болов.

2000 оны зуны Олимпийн наадмыг зохион байгуулах эрхээ Австралийн Сиднейд алдсан Бээжин хот дахин нэрээ дэвшүүлж, 2008 оны зуны Олимпийн ХХІХ наадмыг эх орондоо хүлээн авах өрсөлдөөнд орсон билээ. Энэхүү сунгаанд Францын Парис, Туркийн Истанбул, Канадын Торонто, Тайландын Банконг, Египетийн Каир, Японы Осака, Малайзын Куала Лумпур, Кубын Гавана, Испанийн Севилья хотууд эхний шатанд оролцохоор мэдүүлгээ өгсөн юм. Олон улсын Олимпийн Хорооны Гүйцэтгэх Зөвлөл 2000 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн хурлаараа Бээжин, Осака, Истанбул гэсэн 5 хотод албан ёсоор өрсөлдөх зөвшөөрөл өгчээ. Тэр цагаас эхлэн Зуны Олимпийн ээлжит наадмыг эх орондоо урихын төлөө тэмцэл эхэлж, бүтэн жилийн турш үргэлжилсэн сурталчилгааны компанийн ажил Олон Улсын Олимпийн Хорооны 112-р чуулганы өмнөхөн өндөрлөж, үнэлгээний комиссын ажилтнууд чуулганаас 2 сарын өмнө нэр дэвшигч хотуудтай танилцсан тайлангаа Олон Улсын Олимпийн Хороонд өгсөн байна. Нэр дэвшигч хотуудын төлөөлөгчид Олон Улсын Олимпийн Хорооны ээлжит чуулганд оролцохоор 2001 оны 7 дугаар сарын 13-ны өдөр ОХУ-ын нийслэл Москва хотод хүрэлцэн ирж Олон Улсын Олимпийн Хорооны гишүүд нууц санал хураалтаар Олимпийн эзэн хотыг тодруулав. Эхний шатанд Бээжин хот 44 санал авч илт давуу байсан бол Осака хот 6 санал авч хасагдлаа. Хоёрдугаар шатны санал хураалтанд Бээжин хот 56 санал авснаар

өрсөлдөгчдөө илт давуу ялж, Зуны Олимпийн ХХІХ наадмын Нийслэл хот болов.

### Санал хураалтын дүн

Үе шат	1	2
Бээжин хот	44	56
Истанбул хот	17	9
Осака хот	6	0
Парис хот	15	8
Торонто хот	20	22

### БЭЭЖИН-2008 ОНЫ ЗУНЫ ОЛИМПИЙН ХХІХ НААДАМ

Зуны Олимпийн ХХІХ наадам нэг дэлхий-нэг мөрөөдөл уриан дор зохиогдох ба 2008 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн 20 цагт Бээжин хотын үндэсний цэнгэлдэх хүрээлэнд нээлтээ хийнэ.

Байт харваа, бадминтон, бэйсбол, бокс, буудлага, волейбол, гандбол, спортын гимнастик, уран сайхны гимнастик, дарвуулт завь, дугуй, жүдо, зүлэгний хоккей, каноэ, каяак, морин спорт, сагсан бөмбөг, софтбол, сонгомол бөх, сэлүүрт завь, теннис, триатлон, туялзуур жад, таеквондо, усанд сэлэлт, усанд үсрэлт, уран сайхны сэлэлт, усан поло, хөлбөмбөг, хөнгөн атлетик, хүндийн өргөлт, чөлөөт бөх, ширээний теннис, элсний волейбол зэрэг төрлөөр зохиогдоно. 8 дугаар сарын 24-ны өдөр Олимпийн наадмын хаалтын ажиллагаа болно.

Наадмын албан ёсны бэлэг тэмдгээр таван цагаригийн өнгө бүхий цэнхэр өнгөт Бэйбэй загас, хар өнгөт Жинжин панда бамбарууш, улаан өнгөт Хуанхуан олимпийн гал, шар өнгөт Инин төвдийн гөрөөс, ногоон өнгөт Нини хараацай зэрэг таван амьтан тодорчээ.

## БЭЙЖИН ХУАНИН НИ - БЭЭЖИНД ТАВТАЙ МОРИЛ

### Бэлэгдэл

Бээжин-2008 Зуны Олимпийн ХХІХ наадам албан ёсны бэлэгдэл сахиусаар тодорсон өхөөрдөм хөөрхөн амьтад Бэйбэй загас, Жинжин хулсны баавгай, Хуанхуан галын дөл, Инин төвдийн гөрөөс, Нини хараацай та бүхнийг ийнхүү урьж байна.

Хятадын соёл, урлаг, уламжлал, зан заншилын бэлэгдэл болсон эдгээр таван амьтны нэрийг холбон уншвал Бэй-Жин Хуан-Ин Ни буюу хятад хэлээр Та Бээжинд Тавтай Морил гэсэн үг болно. Олимпийн наадмын бэлэгдэл сахиусаар тодорсон амьтадтай танилцагтун.

Загас Хятадын уламжлалт соёл, урлаг чинээлэг амьдрал, ургацын бэлэг тэмдэг юм. Мөн түүнчлэн сайн жил, сайхан амьдралыг бэлэгддэг Бэйбэй загас нь усан спорт ба таван цагаригийн цэнхэр өнгийг төлөөлжээ.

Жинжин хулсны баавгай бол нүүрэндээ хүүхдийн инээмсэглэл тодруулж, аз жаргал авчирсан хулсны бамбарууш билээ. Түүний бүжиглэж буй байдал, хар цагаан хосолсон үсний долгионоос нь гэнэн итгэмтгий бас ялдам занг харж болно. Хулсны баавгай үндэсний үнэт зүйл бөгөөд хүн бүхэнд эрхэмлэн шүтэгдсэн амьтан юм. Жинжиний үсний засалтыг шаазан урлаач Сон Династи анх дүрсэлсэн бөгөөд өтгөн ой болон хүн байгалийн үзэсгэлэн бүхий л үеийн турш дархлан хамгаалахын төлөөлөл болж сонгогджээ. Жинжин хулсны баавгай нь эелдэг ялдамаас гадна өөдрөг үзэлтэй. Тэр тамирчны хүч чадал, Олимпийн таван цагаригийн хар өнгийг төлөөлсөн байна.

Хуанхуан нь эдгээр амьтдын том ах юм. Тэр галын хүү бөгөөд Олимпийн гал, спортын цог залиг бэлэгддэг. Хуанхуан галд нь зогсож байгаа нь Олимпийн үзэл санааны амин сүнс болсон эв нэгдлийг илэрхийлж байна. Тэр хурднаас хурдан, өндрөөс өндөр, хүчтнээс хүчтэй байхыг уриалж байгаа бөгөөд үргэлж нээлттэй. Хуанхуаны цацарсан гэрэл нь Бээжин-2008 онд халуун дулаан бүхнийг урьж байна. Түүний толгойн дүрс нь Хятадын уламжлал загвар бүхий алдарт Дунхуан хэмээх ханын зургаас сэдэвлэн бүтээжээ.

Хуанхуан бүх бөмбөгтэй тоглоомууд ба таван цагаригийн улаан өнгийг төлөөлж байна.

Инин бүх гөрөөсний адилаар хурдан шаламгай амьтан. Тэр өөрийн газар нутаг бүх дэлхийг маш хурднаар хөндлөн гулд туулж чадна. Инин нь Хятадын газар нутгийн өргөн уудмыг бэлэгддэг. Энэ гөрөөс эрүүл энх, хүн байгалийн харьцааг бэхжүүлэхийг ерөөж байна. Ининий нисэж буй байрлал нь Цинхай (Хөх нуур) Төвдийн гөрөөс нь Хятадад хамгийн түрүүнд дархан цаазат хамгаалагдсан амьтдын нэг юм. Түүний толгойн хээ нь Төвд, баруун Хятадын уламжлалт соёл, угсаатны зүйн загвараар бүтээгдсэн, Инин нь хурдан шаламгай, сэргэлэн хөвгүүн, хөнгөн атлетикийн тэмцээн дэхь хүч чадал, таван цагаригийн шар өнгийг бэлэгдсэн байна.

Хавар зун бүр Бээжингийн хүүхдүүд нийслэлийн тэнгэрт гоёмсог цаасан шувуу хөөргөж, зугаацдаг. Эдгээр цаасан шувуудын загвар дотор уламжлалт шувуу болох алтан жигүүрт хараацай дүрс байдаг. Нинигийн дүрс нь нисэж буй зүйлийг дүрслэх уламжлалаар зурагдсан юм. Түүний алтан жигүүр нь хязгааргүй хөх тэнгэр, их амжилтыг бэлэгддэг. Хараацайг хятад хэлээр Ян гэж нэрлэдэг. Янжин гэдэг нь Бээжин хотын эртний нийслэлийн нэр юм. Нини хараацай ариун цагаан, гэнэн, баяр баясгалантай шувуу. Тэр гимнастикийн спорт болон таван цагаригийн ногоон өнгийг бэлэгддэг.

## ДОПИНГИЙН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН СЕМИНАР БОЛОВ.

БНХАУ-ын засгийн газрын хуралдаанаар хэрэгжүүлж буй хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Азийн хөгжиж буй орнуудын дунд олон улсын семинар зохион байгууллаа. 2007 оны 11 дүгээр сарын 6-20-ны өдрүүдэд Бээжин хотноо зохиогдсон уг семинар Допингийн эсрэг сэдвээр болж өндөрлөв. Семинарт Монгол, Лаос, Вьетнам, Индонези, Мьянмар, Филиппин, Саудийн Араб, Пакистан, Ливан, Сири зэрэг 11 орны 29 төлөөлөгч оролцож, БНХАУ-ын засгийн газрыг ивээн тэтгэсэн энэ семинарын ерөнхий зохион байгуулагч нь Хятадын олон улсын спортын корпораци байв. Манай улсаас МҮОХ-ны ажилтан Н.Цогтсайхан, БТСУХ-ны спортын эмнэлгийн албаны эмч П.Бат-Очир,

ЭМШУИС-ын багш П.Батхуяг нар оролцов. Семинар Бээжин хотын “Beijing Garment Commercial” хэмээх зочид буудалд болж, оролцогчид Хятадын түүх, дэлхийн болон Хятадын допингийн эсрэг үйл ажиллагаа, допингийн эсрэг боловсрол, лабораторийн шинжилгээ, Бээжин-2008 Олимпийн наадмын допингийн хяналтын үйл ажиллагаа, журам зэрэг хэд хэдэн сэдвээр лекц уншжээ. Олимпийн наадамд авах шинжилгээний тоогоор дээд амжилт тогтооно. Наадмын үеэр тамирчдын шээс, цуснаас нийт 4600 дээж авна. Энэ нь өмнөх Афины Олимпоос даруй 1600-аар илүү байх юм байна. Зохион байгуулах хороо допингийн шинжилгээг авахад зориулж, тэмцээний байр, Олимпийн тосгонд 1-8 шинжилгээ зэрэг авах хүчин чадал

бүхий өрөө бэлтгэсэн байна. Семинарын үеэр Хятадын допингийн эсрэг агентлаг албан ёсны нээлтээ хийсэн. Тус агентлаг нь иж бүрэн шинжилгээний лаборатори бүхий 4 давхар байшинд байрлах юм байна. Тус төв нь Олимпийн шинжилгээнд бүрэн зориулагдах бөгөөд Олимпийн наадмын үеэр допингийн асуудлаар 6000 гаруй ажилтан ажиллах юм байна.

#### Ашигласан материал

1. “Өнөөгийн Хятад” сэтгүүл 2006 он №2
2. “Өвөр Монголын өдрийн сонин” 2007 оны 11-р сар
3. [www.mtgnews.com](http://www.mtgnews.com) Олон Улсын Олимпийн Хороо 2007 он

Мэдээллийг бэлтгэсэн Г.Онон